



22130601



MONGOLIAN A: LITERATURE – HIGHER LEVEL – PAPER 1
MONGOL A : LITTÉRATURE – NIVEAU SUPÉRIEUR – ÉPREUVE 1
MONGOL A: LITERATURA – NIVEL SUPERIOR – PRUEBA 1

Wednesday 8 May 2013 (morning)
Mercredi 8 mai 2013 (matin)
Miércoles 8 de mayo de 2013 (mañana)

2 hours / 2 heures / 2 horas

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a literary commentary on one passage only.
- The maximum mark for this examination paper is *[20 marks]*.

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire littéraire sur un seul des passages.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est *[20 points]*.

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario literario sobre un solo pasaje.
- La puntuación máxima para esta prueba de examen es *[20 puntos]*.

Доорх хоёр зохиолын аль нэгийг сонгон уран зохиолын талаас тайлбарлаж бич:

1.

Жалцан нүүр гарыг угаахыг байж түргэнээ очоод үг дуугүй захидлыг шүүрэн авч нээн үзэхэд Мягмар Жалцаны мөрийг даган шагайж хамт уншина. Захидлын үг нь:

Эрхэм хүн Жалцан толилно уу?

5 Энэ сарын дундуур нэгэн захидлыг хүлээн авч үзээд эргэцүүлэн санавал эрхэм хүнээс бичсэн бололтой боловч дурдсан зүйлс нь надад үл холбогдмоор тул их л гайхна. Хэрэв нэр, газрыг ташаарснаар надад ирсэн ахул нээж үзсэн бурууг хүлээн уучлахыг гуйна. Хэрэв нэгэн цагийн уйтгарыг сэргээх зугаа болгон өчүүхэн хүнээр хошигносон ахул дахин мөхөс хүнээр энэ мэт наадахгүй өнгөрүүлэхэд итгэнэ. Хэрэв
10 өчүүхэн хүний бодлого мөхсийг урьдаар толилж нэгэн бүлэг уран үгсээр миний мунхаг сэтгэлийг дэмий л баясгах хэмээсэн ахул хариуд инээн талархахаас өөргүй.

Хэрэв нэгэн цагийн түргэн бодлогоор гэнэт хөгжсөн сэтгэлийг хяналтгүй бичсэн ахул эрхэм хүн мэргэн бодлогоо дахин дахин эргэцүүлэн боловсруулж хянах, нягт хичээнгүйг хадгалалтай аж хэмээн санана.

15 Ийнхүү учраас өчүүхэн хүн өөрийн мунхаг сэтгэлээр хичнээн бодовч эрхмийн шагнасан захидлыг дээр дурдсан дөрвөн зүйл “хэрэв”-ийн аль нэгэнд тохон тогтоож чадахгүй их л болгоомжлохын дээр мөн алин боловч цөм тус бүртээ хяналттай болохыг эрхэм хүний толилоход итгэн ялдар энэхэн зуурын амрыг эрж танай захидлыг олж үзсэн нэгнээр ёслов хэмээжээ.

20 Үүнийг Жалцан түргэн зуур уншаад сайн хүний далд санаа зөвшөөрөнгүй болохыг таньж ихэд баярлан одоо хэрхэхийг Мягмар лугаа зөвлөнө.

Бас Мягмараас хэлэх нь: Адилбишээс манай эхнэрт бичсэн захидал дотор чиний тухай зан байдлыг битүү их л асууж магадласан байна билээ. Тэр лав зөвшөөрөх шинжтэй байнам. Одоо эрхбиш түргэн аргуудыг хэрэглэж завдан
25 “төмрийг халуунд нь давтах” хэрэгтэй хэмээх зэргээр хэлэлцэн байж эрхбиш эрс шаардсан хариу захидлыг дахин улам ойр дотно бөгөөд нарийн тодорхой бичиж явуулах хэмээн шийдвэрлэж яаран хариу захидлыг бичив. Үг нь:

Зүрх сэтгэлийн төвд оршигч үзэсгэлэнт охин Адилбиш толилно уу?

Уул талын өнгөт цэцгүүд будран намирах зөөлөн бороог хүсэх адил чамайг
30 мөрөөдөх миний сэтгэл нэг мөчийг алгасалгүйгээр чиний зүг тэмүүлж, чиний зөвшөөрөнгүй хариу ба түүнийг дагалдсан гэрэлт царайг олж үзэн хамтарч цэнгэхийг хүсэн хүснэ. Ийнхүү өдөр олныг өнгөртөл ямар ч хариу шийдвэргүй зогсоогоор хүлээн ширтэж байтал янаг сэтгэлийн үнэнхүү хүсэл аргагүй бат учир хувь зохиол бүрдэн зохицож энэ өдрийг салхин эргэлдээ алтан хараацай жигүүрийг
35 дэлгэн нисч ирээд миний цээжинд урган дэлгэрэх баярын үгийг долгиуулан буй халуун зүрхний угт нэгэнт шигтгэв.

Тэрхүү баярын үр удахгүй бадам цэцэг мэт дэлгэрэн ургаад нэгэн насны баясгалан сэтгэл зүрхийг бүрхэн эзлэх нь зайлшгүйд хүрэв хэмээн би лавтайяа итгэнэ. Ийнхүү итгэх миний сэтгэлд чиний тухай ямар ч “хэрэв” хэмээн зохион
40 бодох эргэлзлэл яахин төрөх билээ.

Ер ямар сайн уран зурагч болов шувууг зурахдаа түүний дүрсийг зурахаас бус яс махыг нэгэнт ялган зурах нь үгүй болой. Үүнчлэн хүн өөрийн сэтгэлийн үнэнийг үгэнд илэрхийлэн хэлэхээс өөр нээн үзүүлэх аргагүй ажуу. Харин эртний үг “Морины сайныг унаж мэд, нөхрийн сайныг ханилж тань” гэдэг биш үү.

45 Дэмий л “хэрэв”-ийн дотроос “хэрэв”-ийг төөрүүлэн бодож болгоомжлов хэмээн цагийг хойшлуулан намайг зовоох яанам, даруй түргэн хурц мэргэн бодлогодоо ойр холыг бүртгэн хянаад хоёр бие нэгэн хос болох түмэн эхт баяр цэнгэлийг тогтоохыг дахин дахин шавдан гуйна.

Санавал:

50 Сайн хүний өршөөнгүй сэтгэл эрхбиш намайг хөөрхийлөн үзэж дахин удтал мөрөөдүүлэн хүлээлгэхгүйгээр их баярт учруулах буй за хэмээн шууд итгэн санаж гүнээ хүндэтгэн ёслогч Жалцан түргэн хариуг хүлээсээр хоцров хэмээжээ.

Ийнхүү бичиж дуусгаад Мягмар лугаа хамтран уншиж зөвлөн хянаад битүүмжилж, түргэнээ хүргэхийг шавдан захиж Мягмарт өгч явуулав.

55 Тэндээс Жалцан дахин үл мэдэгдэх хариу шийдвэрийг хүлээж гиюүрэх гасланд дахин оров. Харин энэ завсар Жалцан тусгай ажилд томилогдон ойр хөдөө газар явж арваад хоноод ирсэн тул энэ завсрын хэдэн хоног асар удаж зовоосонгүй өнгөрчээ.

М Ядамсүрэн, *Залуу хос* (1937)

2.

Өгөөмөр Зөвлөлт түмний сэтгэлийг хүндэлнэм
Өргөн замбуулинд Монгол нэр минь дуурссаныг
Өндөр огторгуйд Монгол мөр минь дурайсныг
Өнөөдөр бид – Зөвлөлт таны ач гэж дуулнам
5 Ширүүн тулааны талбарт цусаа хамт урсгаж
Шинэ хотын харшид хөлсөө цуг шингээж
Ильичийн гэрлийг нутаг даяар минь түгээсэн
Ижилгүй гавьяаг чинь миний түмэн дуулнам.
Эрдэнэт амиа ч бусдын төлөө өргөсөн
10 Эрдэм, баялгийг ч бусдын төлөө түгээсэн
Энэрэлт өөр түмнийг мэдэхгүй!
Өөр хаанаас ч олдохгүй ийм нөхөр түшсэн
Өлзий дүүрэн эх орныхоо ивээлийг бахаднам
Өнөө энд яваа минь ч нутгийн ач аа!
15 Өнөөдөр энд яваа минь ч нутгийн ач,
Өвлийн шөнө өндийж хөхүүлсэн эхийн ач,
Өргөж намайг дөрөөнд хүргэсэн эцгийн ач,
Өршөөлт гар дээрээ өргөсөн түмний ач!
Өөдөсхөн нялхдаа эхийн хайрыг хөхөж
20 Өсөх залуудаа ханийн хайранд хөгжиж
Өгсөх насандаа үрийн хайраар хүндлүүлж
Өнөө би – хайраар жаргаж явна аа.
Цэнхэр тэнгэрээр дутаагүй шувуу шиг
Цэнгэг усаар зутраагүй загас шиг
25 Цэнгэл жаргалаар дүүрэн явна аа, би.
Ээлт нарны доорхи миний заяа
Эцсийн цагт эргэн хоргодох уяа
Энэ хорвоод эх орон минь ганцхан!
Энэ хорвоод эх орон минь ганцхан
30 Энэрлийн далай ээж шиг минь ганцхан
Эрх чөлөө аз жаргалын минь өөжин
Эгэл энэхэн амьдралын минь диваажин.
Буян заяаны минь эх болсон таныгаа
Бусдын боол болгохгүйн бэлгэдэл болж
35 Босоогоороо үхсэн, шархтай Манлай баатрын
Болд зориг – Монгол хүн биднийх.
Хорвоод эх орноо олсон заяа минь үнэн,
Хоёр олддоггүй амьдралаа өргөх минь үнэн!
Хойч үе минь ч тэгж амьдрах нь үнэн!
40 Энэ хорвоогийн жаргал бүхнийг багтаасан
Эх орон минь ганц байдагтаа үнэтэй
Элбэг хайрыг нь хүртэх нас минь л цөөхөн!

П Пүрэвсүрэн, *Үнэн хайрын өргөл* (1989)